



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/227

Сүхбаатар сум

Сүхбаатар сумын төрийн өмчийн 5 дугаар
цэцэрлэгт тусгай зөвшөөрөл олгох тухай

“Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 30 дугаар зүйлийн 30.1.6, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 353 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сүхбаатар сумын 7 дугаар багт сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж байсан хувийн хэвшлийн “Хөгжилтэй долоон одой” цэцэрлэгийг төрийн өмчид худалдан авсантай холбогдуулан тус суманд орон нутгийн өмчийн 5 дугаар цэцэрлэгийг шинээр байгуулж, сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Сүхбаатар сумын төрийн өмчийн 5 дугаар цэцэрлэгийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгохыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Б.Саранчимэг/-т үүрэг болгссугай.

3. Сүхбаатар сумын төрийн өмчийн 5 дугаар цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/, Боловсрол, соёл урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/ нарт тус тус даалгасугай.

4. Хувийн хэвшлийн “Хөгжилтэй долоон одой” цэцэрлэгийг төрийн өмчид худалдан авсантай холбогдуулан сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/ 93 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ